

ӨДӨР ТУТМЫН СОНИНЫ ЯРИЛЦЛАГЫН
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ОЛОЛТТОЙ ТАЛУУД

Х.Энхтуяа*

* “Отгонтэнгэр” их сургууль, Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D)

Түлхүүр үг: сэтгүүл зүй, мэдээлэл, сонины ярилцлага, нийгэм, ярилцагч, нийгмийн хэсэг бүлгийн сэтгэл зүй

Монголчууд бид зах зээлийн өрсөлдөөнт шинэ нийгэмд шилжиж, ардчилсан нийгэмд амьдрах болсноор сэтгүүлчийн мэргэжил, түүний нийгэмд гүйцэтгэх үүргийн тухай ойлголт, төсөөлөл өөрчлөгдөж байна. Сэтгүүл зүй өөрөө ч нэг намын үзэл сурталжсан, ухуулан таниулах хэлбэрээс мэдээллийн зах зээлээс хамааралтай арилжааны хэлбэрт илүүтэй шилжин ороод байгаа билээ. Өнөөдрийн нийгмийн амьдралын шинэ хэв маяг, аж төрөх ёс, асуудалд хандах хандлага, оюун санааны болон харилцааны өөрчлөлтийн үр дүнд:

- мэдээллийн шинэ хэлбэрээс сэтгүүлч мэргэжил өөрийн үнэн төрхийг хайж,

- сэтгүүл зүй цахим хэлбэрт шилжин даяаршиж,

- сэтгүүл зүй олон төрх, хэлбэр, агуулга, арга барилтай болж,

- сэтгүүл зүй хүлээн авагч олон түмний сонирхлыг улам татах болж,

- сэтгүүл зүй арилжааны хэлбэрт шилжиж,

- сэтгүүл зүйн бичлэг задгай хэлбэртэй болж, шарлаж,

- сэтгүүл зүй өөрөө ёс зүй, мэргэжлийн үнэ цэнээ хайх болсон нь сонины ярилцлагын үр нөлөөг ч бас өөрчилж байгаа билээ.

Сэтгүүл зүй өөрөө даяаршиж, мэдээлэл-харилцааны шинэ хэлбэрт шилжиж байгаа нь зөн билгээс бодит байдалд шилжиж, амьдралыг байгаа өнгө будгаар нь буулгах болсон, хувь хүнээс хамт олны шинжид шилжиж олон ургальч үзэл, олон нийтийн санаа бодлын индэр болсон, элитийн хүрээ нээс хальж олонхийн хэлбэрт шилжсэн, ганцаарчилсан хэлбэрээс харилцан ярилцаж асуудлыг хөндөн, шийдвэрлэхийг зорих болсон, аман хэлбэрээс бичгийн хэлбэрт шилжсэн, хэвлэмэл байдлаас цахим хэлбэрт шилжсэн зэрэг олон давуу талыг бидэнд авч ирж байна.

Орчин үеийн өдөр тутмын сонины ярилцлагыг бичлэгийн бусад төрөл зүйлтэй харьцуулан судалж, эзлэх байр суурийг тодорхойлохоор “Өнөөдөр”, “Өдрийн сонин”, “Зууны мэдээ” сонины 2012 оны нийт дугаарыг шүүж үзэхэд бичлэгийн төрөл зүйлээс 4177 буюу 45,1 хувь нь ярилцлага, 2514 буюу 27,1 хувь нь сурвалжлага, 1494 буюу 16,1 хувь нь тэмдэглэл, 1075 буюу 11,6 хувь нь өгүүлэл байна. Үүнээс үзвэл ярилцлага нь бичигдэх

болон уншигдах байдлаараа бичлэгийн төрөл зүйлүүдийн эхний гуравт багтдаг өргөн хэрэглээтэй жанр болох нь харагдаж байна.

Ерээд оны эхэн үед сонины бичлэгийн төрөл, зүйл бол коммунист сэтгүүл зүйд хүчээр оруулж ирсэн зүйл, мэдээллийг ямар хэлбэрээр хүргэсэн нь бус, харин агуулга нь чухал, иймээс санаагаа гаргаж л байвал төрөл, зүйл хамаагүй гэж ярьж, бичиж байсан нь өнөөдөр эсрэгээр эргэснийг судалгааны дүн харуулав. Энэ нь «Бичлэгийн төрөл, зүйл бол хэн нэг хүн санаанаасаа зохиочихсон зүйл биш, утга зохиолын хөгжлийн явцад аяндаа үүссэн үзэгдэл, мэдээллийг олон өнгө аяс, арга барилаар сонирхолтой хүргэх шаардлагаар буй болсон зүйл»¹ гэж үздэг онолын чиглэл зөв болохыг ямар нэг хэмжээгээр харуулж байгаа юм.

Орчин үеийн нийгмийг төлөвшүүлэгч соёлын хэм хэмжээ, үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх үүргийг сэтгүүлчид гүйцэтгэж байгаа бөгөөд тэд өнөөдөр зөвхөн мэдээллийг түгээгчид бус, нийгмийн санаа бодлыг бүрдүүлэгчид. Өнөөдрийн Монголын иргэний нийгмийн төлөвшилд чухал нөлөө үзүүлж байгаа хүчин зүйлийн нэг нь олон нийтийн мэдээлэл харилцааны хэрэгсэл болж байна. Чөлөөт өрсөлдөөн, хувь хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөг дээдэлдэг ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжсэнээр засаглалын төв нь төр засаг биш, ард түмний эрх ашиг гэдгийг ухамсарлуулан, хэлэх юмтай хүн болгон өөрийгөө илэрхийлэх эрх чөлөөг сонины ярилцлагаар дамжуулан эдлэх болжээ. Хэвлэлээр дамжуулан өөрийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх нь олон нийтийн үзэл бодлыг төлөвшүүлэхэд нөлөөлөх, төр засгийн байгууллагууд зөрчил гаргах, эрх

мэдлээ урвуулан ашиглахын эсрэг тэмцэх, хяналт тавих хэрэгсэл болж эхэлж байна. Харин сэтгүүлчид энэ боломжийг олон түмэнд нээлттэй болгож нийгмийн хэсэг, бүлэг бүрийн төлөөлөлтэй ярилцаж, мэдээлэл солилцдог байх нь чухал юм.

Өнгөрсөн нийгмийн тогтолцооны үед голдуу эрх мэдэл бүхий өндөр албан тушаалын хүмүүсээс, эсвэл амжилт бүтээл гаргасан алдартай хүмүүсийн үгийг сонсож, тэднээс мэдээлэл авахын тулд ярилцлага хийдэг жишиг тогтсоноос шалтгаалан жирийн ард иргэдийн дуу хоолойг ил гаргаж чаддаггүй байсан үе өнгөрч, орчин цагийн сонины ярилцлага ардчилсан нийгмийн мөн чанарыг илэрхийлэгч болж, хэн боловч үгээ хэлж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй болсон байна. Хүн ямагт өөрийгөө илэрхийлэхийг хүсч байдаг бөгөөд энэ хүслийг биелүүлэх боломжийг бидэнд өнөөдрийн ардчилсан нийгэм, түүний дотор чөлөөт хэвлэл олгож байгаа юм. Тиймээс орчин цагийн ярилцлага дараах онцлогуудыг агуулж байна. Үүнд:

- Сэдвийн чөлөөт сонголт – *сэтгүүлчийн эрх чөлөө*,

- Ярилцагчаа чөлөөтэй сонгох эрх чөлөө – *сэтгүүлчийн хувьд хэнээс ярилцлага авах вэ? Ярилцагчийн хувьд ямар сэтгүүлчтэй ярилцах вэ?*

- Хүссэн асуултаа тавьж, мэдээлэл олж авах эрх чөлөө – *сэтгүүлчийн хувьд зорилгодоо хүрэх арга хэрэгсэл, ярилцагчийн хувьд хариулахгүй ч байж болох*,

- Хэлбэрээ чөлөөтэй өөрчлөх эрх чөлөө – *сэтгүүлч зорилгодоо хүрч агуулгаа бүрэн дүүрэн гаргахын тулд өөрийн бичлэгийн өвөрмөцийг илтгэх*,

- Ярилцлагад эх сурвалжийн үзэл бодол, сэтгэлгээний өвөрмөц онцлог,

эрхэлдэг ажил хөдөлмөр, сэтгэл зүйн байдлыг илэрхийлсэн дурын хэсгийг ишлэн авч гарчиг болгох эрэл хайгуул – *гарчигт ач холбогдол өгч, түүний үүргийг илүүтэй онцолж, түүндээ тухайн бие хүний байр суурийг илэрхийлэх арга зэргийг нэрлэж болно.*

Сүүлийн үед бие хүмүүсийн хоорондын харилцаа, түүнийг амжилттай удирдах зэрэг асуудлыг сэтгүүл зүйн ярилцлагад тулгуурлан авч үзэх хандлага гадаадын зарим судлаачдын (G.Killenberg², R.Anderson³, Г.Лазутина⁴, М.Шостак⁵) анхаарлын төвд зүй ёсоор орж, түүнийг бие хүний харилцааны онолд тулгуурлан судлах болжээ.

Сэтгүүлч бодит байдлыг танин мэдэж судлах үйл явц нь нэлээд өвөрмөц онцлогтой бөгөөд судалгааны зорилгын өвөрмөц тал нь сэтгэл зүйн онцгой уур амьсгал бий болгох явдал юм. Сэтгүүлч судалгааны ажлынхаа ихээхэн хэсгийг хүмүүсийн хоорондын харилцаанд тулгуурлан хийж, хүмүүстэй харилцах явцдаа объектын судалгаагаа давхар хийж байдаг. Ингэж хүмүүстэй харилцах явцдаа тэдний дотоод сэтгэлийн гүнд нэвтрэн орж, уг хүний сайн ба саар талыг үнэнээр нь мэдэж авахын тулд хүний онцлогийг илэрхийлэх гол элемент болох биологи, психологи, нийгмийн уламжлалт талыг нарийвчлан мэдэх ёстой болж байна. Ярилцагч, сэтгүүлч бие хүний байдал, тухайн бодит нөхцөлд тулгуурлан хэдэн гол шалтгааныг тодотгож болно. Үүнд: 1. Нийгмийн хэсэг бүлгийн ялгааг тухайн хүн дээр тодотгохдоо: а) түүний нийгмийн байдал, б) баримжааны үнэлгээ, в) нийгмийн идэвхийг харгалзан үзэх; 2. Психологийн ялгаврыг нь тодотгохын тулд: а) тухайн хүний мэдлэгийн хөгжлийн хэр хэмжээ, б)

дотоод сэтгэл, мэдрэх чадвар, в) зан суртахууны болон хүсэл зоригийн тэмүүллийг мэдэх; 3. Психологийн биологийн онцлогийг гаргахын тулд: а) ааш авир, б) зан байдал, в) төрхийг харгалзах, 4. Нөхцөл байдлыг нь тодотгохын тулд: а) тэр хүний зорилго, б) бодол санаа, в) дадал заншлыг тодотгох шаардлагатай болжээ.

“Өнөөдөр”, “Өдрийн сонин”, “Зууны мэдээ” сонины ярилцлагад агуулгын судалгаа хийх явцад нийгмийн хэсэг бүлгийн сэтгэл зүй дараах байдлаар илэрч байгааг тодорхойлж гаргалаа. Үүнд:

I. Ярилцлагаар дамжуулан хэсэг бүлгийн төлөөлөл өөрийн имиж, онцлог, хэрэгцээ сонирхол, зорилго, зорилт, шийдвэр, ухамсар, эрхэм дээд эрмэлзэл, ертөнцийг үзэх үзлээ олон түмэнд харуулж байна. Тухайлбал,

Урлаг, соёлын салбарт ажилладаг уран бүтээлч хүмүүс нийгэм, түүний дотор хүн рүү гол анхаарлаа төвлөрүүлж хандсан байдаг. Тэд чөлөөтэй ярьж, чөлөөтэй сэтгэж чаддаг. Ямар нэг сэдэв, орон зай, цаг хугацаанд баригддаггүй, мэдрэмж сайтай бөгөөд нийгмийн хямрал, хүний өөрчлөлтөд илүү эмзэглэдэг нь харагдаж байна. Жишээ нь «Ц.Түмэнбаяр: Бүтээлүүдээс минь үндэсний үнэр ханхалж байгаасай» (“Өдрийн сонин”. 2012.06.08), «А.Энхтайван: Чингис хаанд тоглохоо цагаан морин жилийн шинийн нэгэнд мэдэж билээ» (“Өдрийн сонин”. 2012.12.19), «С.Болд-Эрдэнэ: Урлагт гологдох хүртлээ Гамлетын дүрээ баяжуулсаар байх болно» (“Өдрийн сонин”. 2012.11.20), «Ш.Доржсүрэн: Хөлсөө урсгаж хийсэн киногоо хүмүүст хүргэх гэсэн юм, өөр санаагүй» (“Зууны мэдээ”. 2012.01.06), «Т.Төмөр: Хүүхдүүд циркийн урлагаас нэгнийгээ хайрлах сэтгэлтэй болж байна»

(“Зууны мэдээ”. 2012.01.10), «Д.Ширмэнтуяа: Хүнд хатуу хандчихаад хайр хүсвэл хариу ирэхгүй» (“Зууны мэдээ”. 2012.01.12), «Л.Оюун: Үйлдвэрт биш сургуульд мөнгө өгсөөр зах зээлээс ухарчихлаа» (“Зууны мэдээ”. 2012.01.03), «М.Анхцэцэг: Хоосон хоносон ч урлагтаа үнэнч байна» (“Зууны мэдээ”. 2012.02.06), «Н.Сувд: Амьдрал бол чиний их сургууль» (“Зууны мэдээ”. 2012.05.01), «Г.Жигжидсүрэн: Зохиолгүй кино суурьгүй барилгатай адил» (“Өнөөдөр”. 2013. 10.22), «А.Мөнгөнзул: Уучилна гэдэг ухаантай шийдвэр болохоос ялагдал биш» (“Өнөөдөр”. 2013.09.11) зэрэг ярилцлагын зочин нь бүгд урлагийнхан байсан бөгөөд тэдгээрийг унших явцад уран бүтээлч бүр ахмад үеийнхэн-чадварлаг багш нараараа бахархаж, тэднийгээ хайрлаж явдаг тухай өгүүлж байлаа. Урлагийн залуу үеийнхний төлөөлөл бүгд өөртөө итгэлтэй байж, бүтээлээ бахдан ярьж, ихийг хийж бүтээх хүсэл тэмүүлэлтэй байхад, алтан үеийнхэн авьяасаа өвлүүлж үлдээхийг хичээсэн, сургасан, өнөөгийн нийгмийн ёс суртахууны өөрчлөлтөд сэтгэл эмзэглэсэн дүр төрх ажиглагдаж байлаа.

Спортынхонтой хийсэн ярилцлагад гол төлөв тухайн цаг үед болсон уралдаан, тэмцээний тухай ярилцсан байдаг. Спортынхон амжилтаараа бахархаж, өөрийн хичээл зүтгэл, бэлтгэлийг бахархан ярьсан, ирээдүйд гаргах амжилтаа амлахын зэрэгцээ төр

засаг, хамт олон, байгууллага зэргээс дэмжлэг хүссэн байх нь түгээмэл юм. Тухайлбал «А.Сүлдбаатар: Монголчууд акробатыг шинэ түвшинд гаргалаа» (“Зууны мэдээ”. 2012.03.06), «Д.Отгонцэцэг: Олимпийг хүрч боломгүй оргил гэж боддог байлаа» (“Өдрийн сонин”. 2012.05.04.), «Боксын холбооны дэд ерөнхийлөгч Н.Баярсайхан: Ц.Элбэгдорж тамирчдаа “гол гаргаж” болохгүй биз дээ» (“Зууны мэдээ”. 2012.05.07) зэрэг ярилцлагаас Монголын циркчид акробатын төрлөөр Монте-Карлогийн 36 дахь наадмаас “Хүрэл алиалагч” цом хүртсэн нь спортын дэлхийн аваргатай тэнцэх шагнал болсон тухай, Олон улсын хэмжээний мастер Д.Отгонцэцэг найман жилийн уйгагүй зүтгэлийн дүнд 2012 оны Олимпод оролцох эрх авч, ааваасаа өвлөсөн хүч, ухаанаар алд-

рын оргил өөд тэмүүлсэн тухай, боксын тамирчид төрөөс дэмжлэг хүсч байгаа зэргийг уншиж болох байна. Судалгаанаас харахад «Зууны мэдээ» сонинд урлаг, спортынхонтой хийсэн ярилцлага түлхүү нийтлэгдэж байв. «Өдрийн сонин»-ы соёл урлагийнхантай хийсэн ярилцлага нь нийтлэлийн өнгө аястай, хөрөглөсөн хэлбэртэй, «Өнөөдөр» сонин дэргэдээ «Таван цагираг» спортын сонинтой учир урлаг, соёлынхонтой хийсэн ярилцлагыг олноор нийтэлдэг байдал ажиглагдаж байлаа.

Улс төрчид сонины ярилцлагыг өөрийн PR, сонгуулийн сурталчилгаа болгон ашиглахыг оролддог.

«

Улс төрчид сонины ярилцлагыг өөрийн PR, сонгуулийн сурталчилгаа болгон ашиглахыг оролддог. Сурвалжлагчийн асуултанд өгч буй тэдний хариултаас улс төрчийн хуримтлуулсан туршилага, нийгмийн байр суурийг тодорхойлох боломжтой байдаг нь энэ төрөл зүйлийн нэг онцлог

юм

»

Сурвалжлагчийн асуултанд өгч буй тэдний хариултаас улс төрчийн хуримтлуулсан туршлага, нийгмийн байр суурийг тодорхойлох боломжтой байдаг нь энэ төрөл зүйлийн нэг онцлог юм. Тухайлбал «УИХ-ын гишүүн Г.Баярсайхан: Ардчилсан нам сонгуульд оролцох галын бэлтгэлээ сайн базаасан» («Өдрийн сонин». 2012.05.11) ярилцлагад намынхаа хийсэн, хийх гэж байгаа ажлын талаар ярьсан, «ИЗНН-ын ерөнхий нарийн бичгийн дарга Г.Ганхүү: Нэр цэвэр, авлигад автаагүй гэсэн имижээрээ бид бусдаас ялгарна» («Өдрийн сонин». 2012.05.22), «МАН-ын нарийн бичгийн дарга Я.Содбаатар: Бид ардын хүүхдүүд. Аавынхаа намыг өвлөн, тойргийг нь өмчилж, нэр дэвших эрхийг нь хувьчилж аваагүй» («Өнөөдөр». 2012.06.25), «Төв аймгийн Ардчилсан намын дарга Д.Доржпүрэв: Яагаад манай нам Засгаас гарч болдоггүй юм бэ?» («Зууны мэдээ». 2012.01.11) зэрэг ярилцлагуудад намынхаа нэр хүндийг өсгөх, өөрсдийгөө сурталчлах зорилгоор ярьж, намаасаа зохион байгуулж буй үйл ажиллагааг таниулсан мэдээлэл өгсөн байлаа.

Дэлхий дахинд алдартай хүмүүс тэр хэрээрээ том асуудал хөндөж, өргөн цар хүрээтэй сэтгэдэг нь тэдэнтэй хийсэн ярилцлагын үр нөлөөг аяндаа өргөдөг байна. Аль ч салбарын мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага тухайн салбарын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тодорхой зорилтот хэрэглэгчдэд өгөхийг зорьж байна. Жишээлбэл «Д.Чинбат: Шинэчилсэн бүртгэлд хамрагдсан иргэдийн үнэмлэхийг шууд хэвлэнэ» («Зууны мэдээ». 2012.01.11), «Ж.Нямдаваа: 14 настай хүүхдүүд тасартлаа ууж үзсэн гэж хариулсан нь эмгэнэл» («Зууны мэдээ». 2012.07.09), «Л.Сэлэнгэ: Шинэ

орифлеймчүүдэд Парис хол биш» («Өдрийн сонин». 2012.05.28), «С.Мөнхсүх: Изинис Эйрвэйз энэ долдугаар сард Бойнг 737-700 болон КЮ 400 онгоцнуудыг үйлчилгээндээ ашиглаж эхэлнэ» («Өдрийн сонин». 2012.04.09) зэрэг ярилцлагын гарчгаас харахад л Иргэний бүртгэлийн газар, Цагдаагийн хэлтэс, Сүлжээний бизнесийнхэн, Иргэний агаарын тээврийн үйлчилгээтэй холбоотой мэдээлэл олон түмэнд илүү хүрч байгаа нь ойлгомжтой байна.

Хүүхдүүд ирээдүйн мөрөөдлөө илүүтэй ярьдаг. Ярилцлага өгч буй хүүхдүүдийн дийлэнх нь авьяаслаг, тэргүүний сурагчид байдаг бол, өндөр настай, ахмад хүмүүс залуу үедээ сургамжилсан, улс эх орныхоо ирээдүйн төлөө санаа зовнисон шинжтэй байдаг байна. Нийслэлийн тэргүүний 5 дугаар бүрэн дунд сургуулийн тавдугаар ангийн сурагч Ц.Ухаанзаяатай хийсэн «Гурван настайгаасаа дуулаад арав гаруй медаль авсан» (Өдрийн сонин. 2012.05.02) ярилцлагад онц сурдаг, сэргэлэн дуучин охин гурван настайгаасаа эхлэн дуулаад жил бүр алт, мөнгө, хүрэл медалийн эзэн болсон, тун удахгүй тайлан тоглолтоо хийх гэж байгаа бүжигчин, дуучин, хулсан хуур тоглодог авьяаслаг охиныг үе тэнхийнхэнд нь үлгэр дууриал болгон таниулжээ.

II. Ярилцлагын ишлэл маягийн гарчиг нь тухайн ярилцагч болон түүнийг хүрээлэн буй бүлэг хүмүүсийн сэтгэл зүй, ухамсрын түвшинг илтгэн харуулах нэг янзын хэрэгсэл болдог нь судалгаанаас харагдлаа. Тухайлбал:

«Ц.Дашдондов: Тортогт сэтгүүл зүйн тогоог хөөлөх хурал хусам ихтэй, ерөм багатай өндөрлөв» («Зууны мэдээ». 2012.01.06) гэсэн ярилцлагад сэтгүүлчдийн байгууллага, түүний үүрэг, цаашдын үйл ажиллагаанд санаа

зовнисон, өнгөрсөн хурлын үр дүнд сэтгэл дундуур байгаа зэрэг нь ажиглагдаж байна, «Ц.Дэмбэрэл: Феодалжсан академийг шинэчилье» (“Зууны мэдээ”. 2012.01.04) гэдэг ярилцлагаас Монгол улсын ирээдүйн хөгжил, төрийн зөв бодлого зохицуулалт, шинжлэх ухааны академийн өнөөгийн бүрэлдэхүүнд сэтгэл дундуур байгаа зэргийг харж болно, «Б.Цогтгэрэл: Сонгуулийн хуульд зөрчилдөөнтэй зүйл, заалт олон байна» (“Зууны мэдээ”. 2012.01.05) ярилцлагад өөрчлөгдөөд байгаа сонгуулийн шинэ хуулинд иргэд, хэсэг бүлгийн эрх ашиг зөрчигдсөн заалтууд орсныг асуудал болгон гаргасан бол, «Уран дархан С.Билгүүн: Бизнесийн орчин таагүй учир нуугдахаас өөр арга алга» (“Зууны мэдээ”. 2012.01.06)) ярилцлагад жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг төрөөс дэмжих үйл ажиллагаа, төрийн үйлчилгээ доголдолтой байгааг шүүмжилсэн байна. Түүнчлэн «Б.Галаарид: Ардчиллын үр шимийг хүртчихээд хэвлэлийн эрх чөлөөг боомилох гэж оролдох нь гутамшиг» (“Зууны мэдээ”. 2012.03.01) ярилцлагад чөлөөт хэвлэл ардчилсан нийгмийн гол илэрхийлэл болж байхад сэтгүүлчийн үйл ажиллагаанд цензур тогтоох гэж оролдож байгааг шүүмжилсэн гэх зэргээр ишлэл гарчиг бүхэнд тодорхой асуудал хөндөж буйг харж болох юм.

III. Ярилцлагын гарчгаас уншигчид хэрэгтэй мэдээллийг шууд авч болдог хэлбэр нэлээд дэлгэрчээ. Жишээ нь: «Д.Доржцэнд: Машинаа оношлуулахаас өмнө заавал даатгуулах ёстой» (“Зууны мэдээ”. 2012.05.11), «А.Сүлдбаатар: монголчууд акробатыг шинэ түвшинд гаргалаа» (“Зууны мэдээ”. 2012.03.06), «Х.Тэмүүжин: Үндэслэлгүй хөрөнгөждөг махан идэштнүүдийг барих боломжтой боллоо» (“Зууны

мэдээ”. 2012.01.24), «Т.Төмөр: Хүүхдүүд циркийн урлагаас нэгнийгээ хайрлах сэтгэлтэй болж байна» (“Зууны мэдээ”. 2012.01.10), «С.Нэргүй: Нойтон хулхийг хуурай аргаар цэвэрлэх нь хамгийн үр дүнтэй» (“Зууны мэдээ”. 2012.01.05), «Архины асуудлаа шийдсэн хүнд чөлөөт цаг гардаггүй» (“Өдрийн сонин”. 2012.-05.01), «Ц.Тулга: Нийслэл, аймгийн төвүүдийг холбосон гол зам дагуух газрыг иргэдэд өмчлүүлнэ» (“Өдрийн сонин”. 2012.05.01) «Б.Бурмаа: Ахуйн бохирдлоос болж гахайн хавдрын дэгдэлт нэмэгдэж байна» (“Өдрийн сонин”. 2012.06.05) зэрэг гарчгаас өөрт хэрэгтэй мэдээллийг олж уншиж болно.

IV. Өнөөгийн сонины ярилцлагад чөлөөт ярилцлага том байр суурь эзлэх болов. Жишээ нь: «Шанз-3 хамтлаг: Шанз яг л аальгүй, эрхэмсэг бүсгүй шиг хөгжим» (“Зууны мэдээ”. 2012.01.04), «Ц.Бавуудорж: Би үнэн дүр төрх, мөн чанараараа болор шиг гэрэлтэж явна» (“Зууны мэдээ”. 2012.01.05), «”Алтан ураг” хамтлагийн ахлагч Б.Эрдэнэбат: Биднийг эв нэгдэл, урлагт хайртай сэтгэл зангиддаг» (“Зууны мэдээ”. 2012.01.16), «Х.Болор-Эрдэнэ: хүн бол хамгийн том брэнд» (“Зууны мэдээ”. 2012.01.19), «Н.Наранбаатар: Биеэ тоох өвчнийг туулаад өнгөрчихсөн» (“ӨС”. 2012.01.26), «О.Сундуй: Багш эрдэм заахаас илүү зүрх сэтгэлд насан туршийн галыг бадраадаг» (“Зууны мэдээ”. 2012.05.29), «С.Саянцэцэг: Хөгжимчин хүн гараа хайрлах ёстой учраас гэрийн ажил хийж үзээгүй ээ» (“Өдрийн сонин”. 2012.06.06), «Д.Бямбацогт: Уран бүтээл төгс биш. Би ч бурхан биш шүү дээ» (“Өдрийн сонин”. 2012.06.05), «Н.Батцэцэг: Инээмсэглэл бол эмэгтэй хүний хамгийн том гоёл» (“Өнөөдөр”. 2012.11.07) зэрэг ярилц-

лагын гарчгаас хувь хүний сэтгэхүйн цар хүрээ, эрх чөлөөт байдал, өгүүлэмж, бодрол гэх мэт олон зүйлийг харж болно.

V. Ярилцлагын агуулга олон түмний санаа бодлыг илтгэн харуулах үр нөлөөтэй хэрэгсэл болж байна. Ялангуяа асуудал дэвшүүлсэн ярилцлагад гол баатар сэтгүүлчийн тусламжтайгаар өөрийн хувьд болон бусад хүмүүсийн хувьд эмзэг сэдвийг хөндөж шийдвэр гаргах түвшний хүмүүст ханддаг. Бас тэдэнд гомдоллодог. Тэд энэ асуудлын хүрээнд сэтгэл зүйн таагүй мэдрэмж тээж, сэтгэл санааны хувьд тогтворгүй болдог. Харин сэтгүүлч тухайн асуудлыг илүү хурц гаргаж ирэхийг зорьж асуултаа тавьдаг байна.

Эрүүл мэндийн сэдвээр хийсэн олонх ярилцлагад мэргэжлийн эмч мэргэжилтэн оролцдог учраас ярилцлага гол төлөв мэдээлсэн хэлбэртэй болдог байна. Ийм ярилцлагаар тухайн эмчийн мэргэжлийн ур чадвар харагддаг. Тухайлбал «Л.Нина: Хушга хүүхдийн оюун санааг сайжруулдаг» («Зууны мэдээ». 2012.01.05), «Г.Нарантуяа: Айдас бол сэтгэцийн эмгэг. Заавал эмчлэх ёстой» («Зууны мэдээ». 2012.01.05), «Д.Ганбат: Архинд донтсон хүн ойр дотныхоо хорин хүнийг өвчлүүлдэг» («Өнөөдөр». 2012.10.24) зэрэг ярилцлагад мэргэжлийн эмч нартай уулзаж эрүүл амьдрахад хэрэгтэй мэдээллийг олон түмэнд хүргэжээ.

Дээрх жишээнүүдээс харахад сэтгүүлч бодит байдлыг танин мэдэж судлах үйл явц нь нэлээд өвөрмөц онцлогтой болсон бөгөөд судалгааны зорилгын өвөрмөц тал нь сэтгэл зүйн онцгой уур амьсгал бий болгох явдал юм. Сэтгүүлч хүмүүстэй харилцах явцдаа тэдний дотоод

сэтгэлийн гүнд нэвтрэн орж, уг хүний эерэг ба сөрөг талыг үнэнээр нь мэдэж авахын тулд хүний онцлогийг илэрхийлэх гол элемент болох биологи, психологи, нийгмийн уламжлалт талыг нарийвчлан мэдэх ёстой болж байна.

Ишлэл

¹ *Норовсүрэн Л.* 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ., х. 16.

² Killenberg G., Anderson R. 1989. Before the Story. Interviewing and Communication Skills for Journalists. St. Martin's Press.

³ Мөн тэнд.

⁴ *Лазутина Г.* 2000. Основы творческой деятельности журналиста. М.

⁵ *Шостак М.* 1999. Репортёр: профессионализм и этика. М.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Баасансүрэн Т.* 2009. Монголын чөлөөт хэвлэлийн хөгжилд үндэсний сэтгүүлчдийн уран чадвар нөлөөлсөн нь. УБ.

2. *Зулькафиль М.* 2009. Сэтгүүлчийн ур чадвар. Тэргүүн боть. УБ.

3. *Норовсүрэн Л.* 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ.

4. Killenberg G., Anderson R. 1989. Before the Story. Interviewing and Communication Skills for Journalists. St. Martin's Press.

5. *Белановский С. А.* Индивидуальное глубокое интервью. М., 2001.

6. *Лазутина Г.* 2000. Основы творческой деятельности журналиста. М.

7. *Лукина М.* Технология интервью: Учебное пособие для вузов. М., Аспект Пресс, 2003.

8. *Шостак М.* 1999. Репортёр: профессионализм и этика. М.

Summary

In this research work, estate of interviews in today's newspapers and compared it to the other writing categories. Also determining changes and drifts in the social psychology through the way of analyzing interviews in the daily newspapers and shows that its achievements.